



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 453

Улаанбаатар хот

“Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай” журам батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.16 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Хороонд бүртгэлтэй үнэт цаас гаргагчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний байгууллагуудад 2014 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон энэ тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн бүртгэлээ шинэчлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

3. Батлагдсан журмын хэрэгжилт болон тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Баталсан  
Хуучин  
Хуучин  
Хуучин

## ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧИД ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ БҮРТГЭХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.16, 24.3 дахь заалтад тусгагдсан үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.16-д зааснаар “үнэт цаасны зах зээлд оролцогч” гэж үнэт цаас гаргагч, зохицуулалттай хуулийн этгээд болон хөрөнгө оруулагчийг;

1.2.2. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.17-д зааснаар “зохицуулалттай этгээд” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.2-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооноос авсан хуулийн этгээдийг;

1.2.3. үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.20-д зааснаар “үнэт цаас гаргагч” гэж үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа хуулийн этгээдийг;

1.2.4. “үнэлгээний байгууллага” гэж хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;

1.2.5. “бүртгэгдсэн этгээд” гэж Хорооны тавьсан шаардлагыг хангаж үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэхээр Хороонд бүртгэгдсэн хуулийн этгээдийг;

1.3. Бүртгэгдсэн этгээд нь энэхүү журамд тавигдсан шаардлагыг биелүүлж ажиллах, үнэлгээчдийн талаарх өөрчлөлтийг тухай бүр Хороонд ирүүлэх үүрэгтэй.

### Хоёр. Үнэлгээний байгууллагад тавигдах шаардлага

2.1. Үнэлгээний байгууллага дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. үнэлгээний байгууллага нь үнэлгээ хийх үйл ажиллагааг 3-аас доошгүй сар эрхэлсэн байх;

2.1.2. Хороо, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт /цаашид “ММУИ” гэх/-ээс зохион байгуулсан үнэт цаасны зах зээлийн талаарх төрөлжсөн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан 2 ба түүнээс дээш орон тооны үнэлгээчинтэй байх;

2.1.3. үнэлгээчид нь тухайн үнэлгээний байгууллагад 3 сараас доошгүй хугацаанд ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;



2.1.4. үнэлгээчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй талаар ММҮИ-ээс тодорхойлолт гаргуулсан байх;

2.1.5. хууль тогтоомжид заасан бусад.

### **Гурав. Үнэлгээний байгууллагын бүрдүүлэх баримт бичиг**

3.1 Энэхүү журмын шаардлагыг хангасан үнэлгээний байгууллага нь Хороонд бүртгүүлэх хүсэлтээ дор дурдсан баримт бичгийн хамт ирүүлнэ:

3.1.1 бүртгүүлэхийг хүссэн өргөдөл /журмын 1-р хавсралт маягт/;

3.1.2. байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.3. орон тооны үнэлгээчдийн тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, /Тэргүүлэх зэргийн үнэлгээчинд хамаарахгүй/ мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;

3.1.4. үнэлгээчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай тодорхойлолт;

3.1.5. үнэлгээний байгууллага нь үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний үйл ажиллагааны журам;

3.1.6. үнэлгээний байгууллагын үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга.

### **Дөрөв. Үнэлгээний байгууллагыг бүртгэх, бүртгэлээс хасах**

4.1. Хороо үнэлгээний байгууллагаас ирүүлсэн баримт бичгийг хүлээн авсанаас хойш ажлын 20 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

4.2. Хороо үнэлгээний байгууллагыг шаардлага хангасан гэж үзвэл үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгэнэ.

4.3. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий мэдэгдлийг хүсэлт гаргасан этгээдэд албан бичгээр мэдэгдэнэ.

4.4. Хороонд бүртгэгдсэн үнэлгээний байгууллагыг дор дурдсан шалтгаанаар бүртгэлээс хасна:

4.4.1. үнэлгээний байгууллага өөрөө хүсэлт гаргасан;

4.4.2. энэхүү журмын 2, 3.1.1-3.1.4-т заасан шаардлагуудын аль нэгийг болон бүгдийг хангахгүй болсон;

4.4.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

4.4.4. бодит бус дүгнэлт гаргасан, дагаж мөрдвөл зохих хууль, дүрэм, журам, стандартыг зөрчсөн, мэргэжлийн ноцтой алдаа гаргасан, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүссэн;

4.4.5 Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

4.4.6. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

4.5. Энэхүү журмын 4.4.2-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээд бүртгэлээс хасагдсанаас хойш 3 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

4.6. бүртгүүлэхээр хүсэлт гаргасан болон бүртгэлтэй хуулийн этгээд энэхүү журмын 4.5-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан үнэлгээний байгууллагад ажиллаж байсан зохих мэргэжлийн болон хууль хяналтын байгууллагаас буруутай нь тогтоогдсон үнэлгээнийг 3 жилийн хугацаагаар авч ажиллуулахыг хориглоно.

4.7. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан үнэт цаасны зах зээлд оролцогчид үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлнө.

4.8. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үнэлгээний үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэсэн, бүртгэлээс хассан тухай шийдвэрийг Хороо ажлын 10 хоногт багтаан үнэт цаас гаргагч, олон нийтэд цахим сүлжээгээр мэдээлнэ.

#### **Тав. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх этгээдийн төрөлжсөн сургалт**

5.1. Үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтыг Хороо, ММҮИ -тэй хамтран зохион байгуулна.

5.1 Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээчид нь үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад 3 жил тутам хамрагдаж, зохих шалгалтыг өгч гэрчилгээ авсан байна.

#### **Зургаа. Үнэлгээний дүгнэлт, түүний хяналт**

6.1. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэхээр бүртгэгдсэн хуулийн этгээд нь үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, олон улсын үнэлгээний стандарт, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам заавар, арга, аргачлалыг мөрдөнө.

6.2. Үнэлгээний байгууллагаас үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний талаар гаргасан тайлан дүгнэлтийг Хорооны Эрсдэлийн үнэлгээ,



судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний газар хянаж хүлээн зөвшөөрөх эсэх талаар үндэслэл бүхий санал, дүгнэлтээ Үнэт цаасны газарт хүргүүлнэ.

6.3. Хороо бүртгэлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, шалгалт хийнэ.

### **Долоо. Хариуцлага**

7.1. Хороо энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад нь мэдэгдэх, үнэт цаасны зах зээлд оролцогчид үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан олон нийтэд мэдэгдэнэ.

7.2. Бүртгэлтэй үнэлгээний байгууллагууд хөрөнгийн үнэлгээг хамтран гүйцэтгэхээс бусад нөхцөлд өөрийн орон тооны үнэлгээчдээс өөр үнэлгээчдийн үнэлсэн хөрөнгийн үнэлгээг баталгаажуулснаас үүсэх аливаа хариуцлагыг тухайн үнэлгээний байгууллага хүлээнэ.

7.3. Бүртгэлтэй хуулийн этгээдийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

---ooOoo---

## БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу -3  
Улаанбаатар -15160  
Монгол улс.

Хэнээс: .....

.....

.....

(өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс, электрон шуудангийн хаяг)

/ Үнэлгээний байгууллагын нэр ХК, ХХК, ЗБН/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн:

№	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувь (мянган .төгрөгөөр)

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /гүйцэтгэх захирал, нэгжгийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргээжлийн эрхлэх албан тушаал байгууллагад

Үнэлгээний үйлчилгээ үзүүлэх үнэлгээчид нь дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны 201 оны ... дугаар сарын ...-ний өдрийн .. дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үнэт цаасны зах зээлд оролцогчийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргах этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

**ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:**

/..... / /..... /  
/гарын үсэг/ /овог, нэр /

/..... / / албан тушаал /

/тамга тэмдэг/